



Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн”-д хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан
/ДУА-2018-03-ГА/



**Эрүүл мэндийн тусламж
үйлчилгээний бодлого,
төлөвлөлт, үйл ажиллагааны
зохион байгуулалт үр дүн
муутай байна.**

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгс	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Ерөнхий мэдээлэл	4-6 6
Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа	<i>Бүлэг 1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь хүн амын өвчлөлийг бууруулахад бодит үр дүн өгөхгүй байна</i>	7-14
Аудитын менежер Х.Наранцацрал	1.1 Орон нутагт нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого төлөвлөлт хангалтгүй байна.	7-11
Ахлах аудитор Ч.Бэрхсайхан	1.2 Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулж байгаа боловч үр дүн муутай байна	12-14
Аудитор Р.Хаш-Эрдэнэ	<i>Бүлэг 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна</i>	14-28
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.	2.1 Эмнэлгийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт, үнэлгээ оновчтой бус байна.	14-25
	2.2 Техник, технологийн хүрэлцээгүй байдлаас зарим эмчилгээ, оношилгоог хийх боломжгүй байна.	25-28
	Дүгнэлт	29
	Зөвлөмж	30
	Шалгагдагч байгууллагын санал, тайлбар	31
	Тайлан баталгаажуулсан тушаал	32-33
	Тайлангийн хавсралтууд	34-50
ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот		
2018 оны 12 дугаар сар		

ТОВЧИЛСОН ҮГС

ЭЭС	Эм эргэлтийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ХАА	Худалдан авах ажиллагаа
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан аудитын сэдвийн төлөвлөгөө, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

“Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, илэрсэн зөрчил дутагдлыг заасан хугацаанд нь арилгуулж, иргэдийн эрүүл мэндийн байдлыг чанарын шинэ түвшинд гаргаж, эрүүл мэндийн салбарыг хуулийн хүрээнд, эдийн засгийн үр өгөөжтэй ажиллуулахад оршино.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- ✓ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үр дүнтэй байгаа эсэх;
- ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээ үр дүнтэй байгаа эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Эрүүл мэндийн тухай хууль;
- ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль;
- ✓ Дархлаажуулалтын тухай хууль;
- ✓ Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль;
- ✓ Үндэсний стандарт MNS 5095:2017 Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа;
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2012 оны 427 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам”;
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2012 оны 375 дугаар тушаалаар батлагдсан “Төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасаг, нэгжийн ажиллах үлгэрчилсэн журам”;
- ✓ Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2012 оны 129/100 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам”, 2-р хавсралтаар батлагдсан “Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт”;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитын арга зүй:

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:

- ✓ Эрүүл мэндийн сайдын 2006 оны 393 тоот тушаалын 1-р хавсралтаар батлагдсан “Төр хариуцах тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, 2-р хавсралтаар батлагдсан “Төр хариуцах тусламж үйлчилгээний жагсаалт”;
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/04 тоот тушаалаар батлагдсан “Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм”;
- ✓ Засгийн газрын 2001 оны 67-р тогтоолоор батлагдсан “Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээний жагсаалт, тарилгын товллол”;
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2001 оны 34 тоот тушаалаар батлагдсан “Сайн дурын дархлаажуулалт хийх журам”, “Нөхөн, нэмэлт, тархвар судлалын заалтаар дархлаажуулалт хийх журам”;
- ✓ Эрүүл мэндийн сайдын 1997 оны 219 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан “Вакциныг төлөвлөх, нөөцлөх, бүртгэх журам”;
- ✓ Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/514 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө”;
- ✓ Бусад холбогдох дүрэм, журмууд, тушаал.

Аудитад аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, өрхийн Эрүүл мэндийн төв, сумын Эрүүл мэндийн төв болон холбогдох бусад эрүүл мэндийн байгууллагуудын 2017 он, 2018 оны 3-р улирлын байдлаарх үйл ажиллагааг хамруулав.

Аудитыг төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй, тулгуур зарчим (АДБОУС 300), гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан, журам, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв. Аудитын арга зүйн дагуу холбогдох байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, санхүүгийн баримт материалыг түүвэрлэн шалгах, мэдээ тайланг гаргуулж тулган баталгаажуулах, зэрэгцүүлэх, харьцуулах, ажиглалт хийх, бодит байдлыг фото зураг авч баримтжуулах зэрэг шаардлагатай горимуудыг хэрэгжүүлэн, цуглуулсан нотлох баримтад харьцуулалт, судалгаа, шинжилгээ хийж дүнг нэгтгэн боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж өглөө.

Аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Ч.Бэрхсайхан, аудитор Р.Хаш-Эрдэнэ нар 2018 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 2019 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийг дуустал хугацаанд гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Дундговь аймагт Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Сум дундын эмнэлэг 2, сумдын Эрүүл мэндийн төв 13, Өрхийн эрүүл мэндийн төв 2, Зоонозын өвчин судлалын төв, Уламжлалт анагаах ухааны төв, Эмийн эргэлтийн сан 15, хувийн ортой эмнэлэг 2, Үүдэн эмнэлэг 18, Эм ханган нийлүүлэх төв, хувийн эмийн сан 13, сувиллын 3 байгууллага эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна.

Аймгийн хэмжээнд нийт 141 их эмч, 35 бага эмч, 34 багийн бага эмч, 149 сувилагч эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

2017 онд нийт 185,581 үзлэг бүртгэгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг 33%, амбулаторийн үзлэг 45.5%, идэвхитэй хяналт 14.2%, гэрийн идэвхитэй хяналтын үзлэг 5.1%, гэрийн дуудлагын үзлэг 2.2%-ийг эзэлж байна. Мөн эмнэлэгт 11,141 эмчлүүлэгч хэвтэж, 11,044 эмчлүүлэгч эмнэлгээс гарсан бөгөөд нийт 79,586 ор хоног ашиглажээ.

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан:

- ✓ Цусны эргэлтийн тогтолцооны өвчлөл үүнээс 52.4 хувь нь артерийн даралт ихсэх өвчин;
- ✓ Шээс бэлгэсийн тогтолцооны өвчлөл үүнээс 85.3 хувь нь бөөрний үрэвсэлт өвчин;
- ✓ Хоол шингээх эрхтэний өвчлөл үүнээс 35.5 хувь нь шүдний өвчлөл, 35.4 хувь нь элэг цэсний өвчлөл;
- ✓ Бэртэл хордлого ба бусад шалтгаант өвчлөл үүнээс 45.4 хувь зам тээврийн ослоос шалтгаалсан өвчлөл тус тус эзэлж байна.

Бүлэг 1

• Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь хүн амын өвчлөлийг бууруулахад бодит үр дүн өгөхгүй байна

1.1 Орон нутагт нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлт хангалтгүй байна.

Хүн амын өвчлөлд нөлөөлж буй хүчин зүйл, гарч буй үр дагаврын судалгааг орон нутагт системтэй, тасралтгүй хийхгүй байгаа нь иргэдийн эрэлт, хэрэгцээнд үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оновчтой хүргэхэд тулгамддаг асуудлыг шийдвэрлэх арга замыг тусгасан бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

- Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын дэд хөтөлбөрийг 2017 оны 06 сарын 19-нд Засаг даргын тушаалаар батлан, хэрэгжүүлж эхэлж байна.
- Дархлаажуулалтын хөтөлбөр боловсруулаагүй байна. Энэ нь Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3¹, 5.3.2²-т заалтуудыг зөрчиж байна.

Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын дэд хөтөлбөрийн 2017, 2018 оны хэрэгжилтийг тооцож, дүн шинжилгээ хийгээгүй, хэрэгжилт дутуу цаашид анхаарах ажлуудыг тодорхойлон, дараа жилүүдийн төлөвлөгөөнд тусгаж ажиллаагүй байна.

Энэ нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хүн амын эрэлт, хэрэгцээнд нийцэж байгаа эсэх, өвчлөл, хүн амын дундаж наслалтын түвшинд гарч буй өөрчлөлт, улмаар бодлогын үр дүн, үр нөлөөг тооцох боломжгүй болгож, хэрэгжилтийг саармагжуулах үр дагавартай.

Иймд “Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын дэд хөтөлбөр”-ийн 6.1³, 6.2⁴, 6.3⁵-д заасны дагуу хяналт шинжилгээ, үнэлгээг тасралтгүй хийж, сайжруулах арга хэмжээ авч байх шаардлагатай байна.

¹ Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэртээ дархлаажуулалтыг зохион байгуулах талаар дараахь үүрэг хүлээнэ:

² Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг дархлаажуулах тусгай хөтөлбөр батлах.

³ Бодлогын хэрэгжилтийн явцын хяналт шинжилгээ, үнэлгээг ЭМГ нь жил бүр, хөндлөнгийн үнэлгээг 2 жил тутамд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтэс хийнэ.


⁴ Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийгдэх хяналт шинжилгээг Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322-р тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмыг мөрдөх бөгөөд түүнд тусгагдсан арга зүйг ашиглана. Хяналт шинжилгээ, үнэлгээ тасралтгүй явагдана.

⁵ Аймгийн ЭМГ нь дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт тус бүрийн хүрэх үр дүнгийн болон шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг гаргаж, хэрэгжилт үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлийн болон аймгийн ИТХ, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын хуралдаанд танилцуулна.

Улс, аймгуудын дунджаас өндөр, жил бүр нэмэгдэж байгаа өвчлөлд зонхилон өртөж буй хүн амын бүлгийг тодорхойлж, өвчлөлийн суурь шалтгаанд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг аймгийн эрүүл мэндийн бодлого, төлөвлөлтөнд тусгаж, үр дүнг тооцож ажиллахгүй байна.

Дундговь аймагт 10,000 хүн амд эзлэх нийт өвчлөлийн тоо сүүлийн 10 жилд аймгуудын дунджаас бага үзүүлэлттэй байна. /График 1/

График 1



2017 онд 10,000 хүн амд ногдох өвчлөл өмнөх оноос 427 промиллоор буурсан боловч сүүлийн 10 жилийн дундаж⁶ өсөлт 105.1 хувь буюу 5.1 хувийн өсөлттэй байна.

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаант өвчлөлийн өсөлт, бууралтыг дараах хүснэгтээр харууллаа. /Хүснэгт 1/

Хүснэгт 1

	2013-2017 оны өсөлтийн дундаж хувь	2017.11 сар өвчлөлийн тоо 10,000 хүн амд	2018.11 сар өвчлөлийн тоо 10,000 хүн амд	Өсөлтийн хувь
	1	2	3	3/2*100%
Зүрх судасны тогтолцооны өвчин	95.7	377.0	515.1	136.6
Амьсгалын тогтолцооны өвчин	124.5	817.3	977.5	119.6
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	102.4	709.9	1,176.6	165.7
Шээс бэлгийн тогтолцооны өвчин	101.5	324.6	464.6	143.1

⁶ Өсөлтийн дунджийг геометр дунджаар тооцоолов

Осол болон гадны бусад шалтгаант гэмтэл, өвчлөл	133.4	148.8	137.3	92.3
---	-------	-------	-------	------

Хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаант өвчин 2018 оны эхний 11 сарын байдлаар “Осол болон гадны бусад шалтгаант гэмтэл, өвчлөл”-өөс бусад өвчлөл өмнөх оны мөн үеэс 19.6 хувиас 65.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Сүүлийн 5 жилийн дундаж өсөлт “Амьсгалын тогтолцооны өвчин” 124.5 хувь, “Хоол боловсруулах тогтолцооны өвчин” 102.4 хувь, “Шээс бэлгэсийн тогтолцооны өвчин” 101.5 хувь, “Осол болон гадны бусад шалтгаант гэмтэл, өвчлөл” 133.4 хувийн өсөлттэй, “Зүрх судасны тогтолцооны өвчин” 95.7 хувийн бууралттай байна.

Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаант өвчлөлийн өсөлт, бууралтыг дараах хүснэгтээр харууллаа. /Хүснэгт 2/

Хүснэгт 2


Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаант өвчлөл	2013-2017 оны өсөлтийн дундаж хувь
Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин	98.4
Хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшин	99.2
Осол, гэмтэл болон гадны шалтгаант өвчний шалтгаант нас баралтын түвшин	111.0
Хоол боловсруулах тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин	90.0
Амьсгалын тогтолцооны өвчний шалтгаант нас баралтын түвшин	87.5

2017 онд нас баралтын тэргүүлэх 5 шалтгаант өвчлөл өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн 5 жилийн өсөлтийн дунджаар “Осол, гэмтэл болон гадны шалтгаант нас баралт” 111.0 хувийн өсөлттэй, бусад өвчлөлөөс шалтгаалсан нас баралт буурсан үзүүлэлттэй байна.




Зарим төрлийн хорт хавдрын нас баралт улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байна.


Элэгний хорт хавдрын нас баралт



Улаан хоолойн хорт хавдрын нас баралт




Уушгины хорт хавдрын нас баралт



Элэгний хорт хавдрын нас баралт улсын дундаж 5.2, Дундговь 5.4, Улаан хоолойн хорт хавдрын нас баралт улсын дундаж 0.8, Дундговь 1.5, Уушгины хорт хавдрын нас баралт Улсын дундаж 1.3, Дундговь 2.4

2017 онд халдварт өвчин 10,000 хүн амд 110.5 промилл буюу өмнөх оноос 34.2 промиллоор буурсан боловч аймгуудын дунджаас 3.7 промиллоор өндөр байна. /График 2/

График 2



Мөн сүүлийн 10 жилийн аймгуудын өсөлтийн дундаж 96.8 хувь буюу 3.2 хувийн бууралттай байхад, Дундговь аймагт 100.6 хувь буюу 0.6 хувийн өсөлттэй байна.

Өмнөх жилүүдээс өсөлттэй, улсын дунджаас өндөр үзүүлэлттэй халдварт өвчнийг авч үзье. /Хүснэгт 3/

Хүснэгт 3

Халдварт өвчин	2013	2014	2015	2016	2017
В вирус гепатит	22	6	8	5	8
Салхинцэцэг	69	77	24	173	193
Гар хөл амны өвчин		4	29	61	105
Сүрьеэ	22	27	16	30	27

В вирус гепатит 2017 онд 8 бүртгэгдэж өмнөх оноос 3-аар өсч, 10,000 хүн амд 1.8

буюу улсын дунджаас 0.1 промиллоор өндөр үзүүлэлттэй байна.

Салхинцэцэг өвчин 2017 онд 193 бүртгэгдэж өмнөх оноос 20-оор өсч, 10,000 хүн амд 43.4 буюу улсын дунджаас өндөр үзүүлэлттэй байна.

Гар, хөл амны өвчин 2017 онд 105 бүртгэгдэж өмнөх оноос 44-өөр өсч 10,000 хүн амд 23.6 буюу улсын дунджаас 3.8 промиллоор өндөр байна.

Иймд хүн амын өвчлөлийн болон нас баралтын тэргүүлэх 5 шалтгаант өвчлөл, халдварт өвчин болон жил бүр нэмэгдэж байгаа өвчлөлийн зонхилон тохиолдож буй хүн амын бүлгийг тодорхойлж, цаг хугацааны давтамжийг гарган, өвчлөлийн суурь шалтгаанд чиглэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг нийгмийн эрүүл мэндийн бодлого, төлөвлөлтөд тусган ажиллах шаардлагатай байна.



Орон нутгийн газар зүйн байршил, цаг агаарын нөхцөл байдал, усны чанар, хоол хүнс, давсны хэрэглээ зэрэг хүний эрүүл мэндэд нөлөөлдөг онцлог үзүүлэлтүүдэд судалгаа, дүн шинжилгээ хийхгүй байна.

МХГ-аас аймгийн хэмжээнд хэрэглэж буй ундны усны эх үүсвэрт жил бүр шинжилгээ хийдэг боловч үүнийг эрүүл мэндийн байгууллагууд ашиглаж, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгаа талаар дүгнэлт хийхгүй байна.

Цөөн сумдын усны чанарын зарим үзүүлэлт MNS 0900:2018⁷ стандартад заасан ундны усны зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс өндөр үзүүлэлттэй байна.

Тухайлбал усны хатуулгийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ 7.0 мг эквивалент/литр бол Гурвансайхан 7.2, Дэлгэрхангай 7.9, магнийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ 30.0 мг/л бол Хулд 34.1 мг/л, Дэлгэрхангай 35.3 мг/л, Гурвансайхан 52.3 мг/л-ийн үзүүлэлттэй байна. /Хавсралт 1/

Усны чанаргүй байдал нь хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа талаар сумдын эмч нар тайлбарласан боловч МХГ-ын шинжилгээний дүнгээр дийлэнх үзүүлэлт зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байгаа нь эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн байгууллага хоорондын уялдаа холбоо муу байгааг илтгэж байна.

Иймд усны чанар, агаар, хөрсний бохирдол, хоол хүнсний хэрэглээнээс шалтгаалан хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтоож, бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай байна.

Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад гэр бүл, хамт олон, хувь хүний оролцоог нэмэгдүүлэх, эрүүл аж төрөх зөв дадлыг төлөвшүүлэх нь зүйтэй байна.

⁷ /Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ/

1.2 Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулж байгаа боловч үр дүн муутай байна.

ЭМГ-ын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсээс 2018 онд 45 сэдвийн хүрээнд иргэдийн эрүүл мэндийн орчныг бүрдүүлэх, боловсрол олгох сургалт, сурталчилгааг хийж давхардсан тоогоор нийт 38,000 иргэдийг хамруулсан байна.

Өмнөх жилүүдийн хүн амын өвчлөлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцлийг тодорхойлон, дараа жилүүдийн зорилтот түвшин, хүрэх үр дүн, харьцуулах шалгуур үзүүлэлтийг урьдчилан тогтоож үнэлгээ хийгээгүй, мөн зарим өвчлөл жил бүр өсч байгаа /бүлэг 1.1-ээс харна уу/ зэрэг нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа оновчтой бус байгааг илтгэж байна.

Иймд нийгмийн эрүүл мэндийн бодлого, төлөвлөлт /бүлэг 1.1-д бичигдсэн зөвлөмж/-ийн хүрээнд урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэн, үр дүнг тооцож, цаашид анхаарах асуудлыг төлөвлөн ажиллах шаардлагатай байна.



Вакцины устгалын хэмжээ өндөр мөн тооцооллыг буруу хийж, тайлан, мэдээ алдаатай илэрхийлэгдэж байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд товллын 7 нэр төрлийн 13,509 хүн тун вакцин хийхээр төлөвлөж, 6,917 вакцины эхний үлдэгдэл дээр 20,900 вакцин хүлээн авч, 13,219 хүн тун вакцин хийж, 7,489.3 мянган төгрөгийн 11,514 хүн тун вакциныг устгасан байна.



**13,219 хүн
тун вакцин
тарьсан**



**11,514 хүн
тун вакцин
устгасан**

2018 онд товллын 7 нэр төрлийн 11,761 хүн тун вакцин хийхээр төлөвлөж, 3,175 вакцины эхний үлдэгдэл дээр 30,200 вакцин хүлээн авч, 10,484 хүн тун вакцин хийж, 13,619.6 мянган төгрөгийн 6,792 хүн тун вакциныг устгасан байна.
/Хавсралт1/



Энэ нь вакцин 5 хүн тун, 10 хүн тун зэрэг савалгаатай байдаг, зарим вакциныг задалснаас хойш 6 цаг, 1 хоногийн дотор хэрэглэх ёстой тул вакцин задалснаас хойш дээрх хугацаанд хүн ирэхгүй бол устгах шаардлагатай болж байна.

Сумдын вакцин устгалын хэмжээг аймгийн хэмжээнд нэгтгэн гаргаж дүн шинжилгээ хийхгүй байна.

Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумын ЭМТ, Эрдэнэдалай, Говь-Угтаал сумын Сум дундын эмнэлгийн ЭМГ-аас хүлээн авсан вакцины захиалгын тоог ЭМГ-ын сумдад хуваарилсан вакцины баримттай тулгахад 913 хүн тунгийн зөрүүтэй байлаа. */Хавсралт 2/*

Мөн вакцины захиалгын хуудсанд тамга тэмдэг дарж, гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.

Сумын ЭМТ, Сум дундын эмнэлгээс хийсэн сайн дурын вакцины төлбөр хүлээн авсан, төвлөрүүлсэн анхан шатны баримт байхгүй байна.

Эдгээр алдаа дутагдал нь вакцин хүлээн авсан, хүлээлгэн өгсөн байгууллага, албан тушаалтантай тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны баримтыг бүрэн хөтөлж, тайлагнахгүй байгаатай холбоотой байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5⁸, 13.6⁹, 13.7¹⁰, 14 дүгээр зүйлийн 14.4.1¹¹, 14.5¹²-д заасныг тус тус зөрчиж байна.


Тус зөрчлийг арилгуулахаар холбогдох албан тушаалтанд хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Урьдчилан сэргийлэх үзлэг, вакцинжуулалт, дархлаажуулалтад иргэдийн хамрагдалтын хувийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн талаар ухуулга сурталчилгаа хийж, оролцоог нэмэгдүүлэн, вакцин устгалын хэмжээг бууруулах шаардлагатай байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дийлэнх хувь нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.

График 3

Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдсан иргэд, тоо, хувь, хөдөлмөр эрхлэлтийн ангиллаар



Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагдаж байсан уу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан 1099 иргэний 785 хүн тийм, 314 хүн үгүй гэж хариулсан. Төрийн албан хаагчид үзлэгт харьцангуй их

хамрагддаг бол хувийн хувийн хэвшлийн байгууллагын ажилтнуудын үзлэгт хамрагдах байдал бага байна.

⁸ Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.


⁹ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

¹⁰ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

¹¹ аж ахуйн бүх ажил, гүйлгээ;

¹² Аж ахуйн нэгж, байгууллагын аж ахуйн ажил, гүйлгээ нь аль улсын нутаг дэвсгэрт гарснаас үл хамааран холбогдох анхан шатны баримт, бүртгэлийн маягтыг энэ хуульд заасны дагуу бусад баримт, бүртгэлийн маягттай хамт хадгална.

График 4



Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамрагддаг гэж хариулсан дээрх хүмүүсээс 43 хувь нь үзлэг оношилгоог сайн хийдэг, 50 хувь нь дутуу хийдэг, 7 хувь нь огт хийдэггүй гэж хариулсан байна.

Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог эрүүл мэндийн бодлого төлөвлөлттэй уялдуулан, зонхилон тохиолдож байгаа, жил бүр өсөн нэмэгдэж буй өвчлөлд үндэслэн хүн амын эрсдэлт бүлэгт чиглэн зохион байгуулвал үр дүнтэй байна.

Бүлэг 2

• Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах шаардлагатай байна.

2.1 Эмнэлгийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хяналт, үнэлгээ оновчтой бус байна.



Нэгдсэн эмнэлэг амбулаторын хүлээгдлийн хугацааг бодитоор тооцохгүй байна.

Эмчид үзүүлэх дугаарыг 2-оос илүү хоног хүлээгдэх тохиолдолд олгодоггүй, тухайн үед ирсэн үйлчлүүлэгчийг бүртгэж авдаггүй дараагийн өдөр ирж дугаар авахаар явуулдаг нь хүлээгдлийн хугацааг бодитоор тооцдоггүй болохыг харуулж байна.

Аудитаар 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөс 14-ны өдөр Нэгдсэн эмнэлгийн дугаар олголтын байдалд ажиглалт хийхэд Лхагва гарагийн үдээс хойш Дотрын тасгийн эмчид үзүүлэх дугаар Баасан гараг хүртэл олгогдож дууссан тул Пүрэв, Баасан гарагуудад ирсэн 15 үйлчлүүлэгчийг дараагийн 7 хоногийн Даваа гарагт ирэхээр явуулсан.

Эдгээр хүмүүсийг ирсэн өдрөөс эхлэн хүлээгдлийн хугацааг тооцоогүй, Даваа гарагт дахин ирсэн өдрөөс эхлэн тооцсон нь хүлээгдэл бодитой бус гарах шалтгаан болж байна.



Энэ нь Эрүүл мэндийн сайдын 427 тоот тушаалаар батлагдсан “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх журам”-ын 2.3¹³, 2.4¹⁴-д заасныг зөрчиж байна.

Иймд хүлээгдлийн хугацааг үйлчлүүлэгчийн анх эмнэлэгт ирсэн өдрөөс тооцож, хүлээгдэл үүсч буй шалтгаан нөхцлийг тодорхойлж, бууруулах арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Дугаар авахаар хүлээж буй хүмүүс аль эмчид хэдэн дугаар үлдсэн, дугаар байгаа эсэхийг дугаар олгогч дээр очих хүртэл мэддэггүй, дугаар дууссаныг мэдэхгүй хүлээж цаг алдах тохиолдол байсан.

Иймд дугаар олголт болон хэдэн дугаар үлдсэн талаарх мэдээллийг дугаар авахаар хүлээж буй хүмүүст ил тод мэдээлж байх хялбар арга замыг судлаж шийдвэрлэх нь зүйтэй байна.

График 5

Иргэдээс авсан санал асуулгаар эмчид үзүүлэхэд 1-2 хоног хүлээдэг бол, хэвтэн эмчүүлэхэд 1-3 хоног хүлээдэг гэсэн хариулт өндөр хувийг эзэлж байна.

“Та нэгдсэн эмнэлэгт эмчид үзүүлж, оношилгоо, шинжилгээ хийлгэхэд хэр хугацаа зарцуулдаг вэ?” гэсэн асуултад 1,152 хүн хариулснаас 461 хүн буюу 40 хувь нь 1-2 хоног хүлээдэг гэж хариулсан бол 180 хүн буюу 15.6 хувь нь хүлээгдэл их учраас өөр эмнэлэгт ханддаг гэж хариулсан байна.



¹³ Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийн мэдээнд эмнэлгийн удирдлагууд 7 хоног бүр дүгнэлт хийн хэлэлцэж, шалтгааныг тодорхойлох, байгууллагынхаа түвшинд хүлээгдлийг бууруулах, арилгахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

¹⁴ Эрүүл мэндийн байгууллагууд нь өвчтөн, үйлчлүүлэгчдийг эмчид үзүүлэх, оношилгоо, шинжилгээ хийлгэхийн тулд 2-оос дээш, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхийн тулд 3-аас дээш хоног хүлээлгэж байгаа тусламж, үйлчилгээний нэр төрөл, кабинет, тасаг, нэгжийн хүлээгдлийн мэдээг сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн байдлаар тооцож дараагийн түвшинд мэдээлнэ.

Хүснэгт 4

№	Аймгийн эмнэлэгт /Нэгдсэн эмнэлэг, Уламжлалт анагаах ухааны төв, сумын Эрүүл мэндийн төв/ хэвтэн эмчлүүлэхэд хэр удаан хүлээдэг вэ?		
	Хариулт	Хариултын тоо	Нийт хариултад эзлэх хувь
1	Хүлээгдэлгүй шууд хэвтэн эмчлүүлдэг	214	20.0
2	1-3 хоног хүлээдэг	330	30.8
3	3-аас дээш хоног хүлээдэг	281	26.2
4	Хүлээгдэл их учраас өөр эмнэлэгт ханддаг	247	23.0
Нийт		1,072	100.0


Аймгийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхэд хэр удаан хүлээдэг вэ? гэсэн асуултад 1,072 хүн хариулснаас 330 хүн 1-3 хоног хүлээдэг гэж хариулсан бол 247 хүн хүлээгдэл их учраас өөр эмнэлэгт ханддаг гэж хариулсан байна. /Хүснэгт 4/



Төлбөрийг нь төр хариуцах эмийн жагсаалтын талаар иргэд, олон нийт мэдээлэл муутай байна.

Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалтын талаар мэдэх үү? гэсэн асуултанд 1,155 хүн хариулснаас 691 хүн

Төлбөрийг нь төр хариуцан амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалтын талаар мэдэх үү?



Мэднэ



Сонсож байсан сайн мэдэхгүй



Огт мэдэхгүй

сонсож байсан сайн мэдэхгүй, 263 хүн буюу 22.8 хувь нь огт мэдэхгүй гэсэн хариулт өгсөн.

Энэ нь иргэд төлбөрийг нь төр хариуцан

амбулаториор эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалтын талаар мэдээлэл муутай байдаг нь харагдаж байна.



Худалдан авах ажиллагааг журмын дагуу зохион байгуулахгүй байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд 740.7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах төсөв батлагдсанаас, 662.5 сая төгрөгийн эм худалдан авахад тендер зарлаж, 78.2 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тендер зохион байгуулалгүй шууд худалдан авсан.

2018 онд 880.1 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах төсөв батлагдсанаас, 703.4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад тендер зарлаж, 176.7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тендер зохион байгуулалгүй шууд худалдан авсан.

Хүснэгт 5
сая төгрөгөөр

	Батлагдсан төсөв		Тендер зарласан төсөв		Тендер зохион байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн төсөв	
	2017	2018	2017	2018	2017	2018
Нэгдсэн эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгсэл	506.7	659.5	455.0	584.4	51.6	75.1
Сумдын Эрүүл мэндийн төвийн эм, эмнэлгийн хэрэгсэл	234.0	220.6	207.5	119.1	26.5	101.6
Нийт	740.7	880.1	662.5	703.5	78.2	176.7

Тендер шалгаруулалт явуулахгүй шууд худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4¹⁵, 8.5¹⁶, 8.1.2¹⁷, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-д заасныг тус тус зөрчиж байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын үзүүлэлтийг тендерийн баримт бичигт тусгаагүй, чанар ба үнэлгээний харьцуулалтаар оноо өгч тендер шалгаруулалт явуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7¹⁸, 28.7.5¹⁹-д заасныг зөрчиж байна.

Мөн аймагт эмийн чанарыг шалгах лаборатор байхгүй байгаа нь шаардлага хангаагүй, чанар муутай эм хэрэглэх эрсдэлийг бий болгож байна.

Иймд зарим эмийг лабораторын шинжилгээний дүгнэлттэй ирүүлж байх шаардлагыг тендерийн баримт бичигт тусган, үнэлгээ хийж, тендер шалгаруулалтыг зохион байгуулж байх нь зүйтэй байна.

¹⁵ Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

¹⁶ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.


¹⁷ шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

¹⁸ Шаардлагад нийцсэн тендерийг дараахь байдлаар харьцуулж үнэлнэ:

¹⁹ эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад чанар ба үнэлгээний харьцуулалтаар өндөр оноо бүхий тендерийг “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер гэж үзнэ

Тендер зохион байгуулан худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааны мэдээллийг дараах диаграммаар харууллаа.

сая төгрөгөөр



Тендер шалгаруулалтын журмыг буруу сонгосон, гэрээ байгуулалгүй худалдан авалт хийсэн байна.

2017 онд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 46 багцын худалдан авах ажиллагаанд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөж 34 багцын тендер шалгаруулалт амжилттай болж, 12 багц амжилтгүй болж тендер шалгаруулалтын хязгаарлагдмал журмыг мөрдсөн боловч дахин амжилтгүй болсон.

Амжилтгүй болсон тендерийн 4 нь Нэгдсэн эмнэлгийн багц бөгөөд худалдан авалтын шууд гэрээ байгуулсан, 8 нь сумдын ЭМТ-ийн багц бөгөөд гэрээ байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

2018 онд эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 48 багцын худалдан авах ажиллагаанд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөж 31 багцын тендер шалгаруулалт амжилттай болж, 17 багц амжилтгүй болж тендер шалгаруулалтын хязгаарлагдмал журмыг мөрдсөн боловч дахин амжилтгүй болсон.

Амжилтгүй болсон тендерийн 13 нь Нэгдсэн эмнэлгийн багц бөгөөд худалдан авалтын шууд гэрээ байгуулсан, 4 нь сумдын ЭМТ-ийн багц бөгөөд гэрээ байгуулалгүй шууд худалдан авалт хийсэн байна.

Нээлттэй тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судлаж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлтийг оруулж дахин нээлттэй тендер шалгаруулалт явуулалгүй хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмыг мөрдсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4²⁰-д, 30.4.1²¹-д, 30.4.2²²-д гэж заасныг тус тус зөрчиж байна.

Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа эм, эмнэлгийн хэрэгсэл нэг бүрийн үнийг тодорхойлоогүй, зөвхөн багцын үнийг тогтоосон байна.

Энэ нь тендерт оролцогчийн ирүүлсэн эм нэг бүрийн үнийг урьдчилан тогтоосон үнэтэй харьцуулж, дүн шинжилгээ хийх боломжгүй байдлыг бий болгож байна.

Мөн сумдын ЭМТ-д 2017 онд 12 багцын 156.5 сая төгрөгийн, 2018 онд 17 багцын 107.0 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээнд эмийн үнэ, нийлүүлэлтийн хуваарийг тусгаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.3²³, 40 дүгээр зүйлийн 40.3²⁴-д заасныг тус тус зөрчиж байна.

Гэрээ байгуулалгүй шууд худалдан авалт хийх нь үнийн өөрчлөлтийн эрсдэл бий болох, шаардлагатай эмийг хуваарийн дагуу авч чадахгүй байх, нийлүүлэгч компанитай тооцоо хийж, хариуцлага тооцох нөхцөл бүрдэхгүй байх зэрэг эрсдэл, үр дагаварыг үүсгэж байна.

Тендер шалгаруулалт явуулж, гэрээ байгуулах хүртэлх хугацаанд шаардлагатай эмийг тендер зарласан төсвөөс шууд худалдан авч байна.

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулж гэрээ байгуулах хүртэлх үйл явц, хугацааг 2017, 2018 оны байдлаар харууллаа.

Эмнэлгүүдийн 2017 оны эмийн төсөв 12 сард батлагдаж, үнэлгээний хороо мөн адил 12 сард байгуулагдаж, урилгыг 12 сарын 22-ны өдөр нийтэлж, үнэлгээг нийт 10 хоногт хийж, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх эхний гэрээг 2 сарын 14-ний өдөр байгуулсан бол сүүлийн гэрээг 5 сарын 1-ний өдөр байгуулсан байна.



²⁰ /Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:/

²¹ /тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах;/

²² /энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах;/

²³ энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах.

²⁴ Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана:

2018 оны эмийн төсөв 12 сард батлагдаж, үнэлгээний хороо 1 сард байгуулагдаж, урилгыг 1 сарын 8-ны өдөр нийтэлж, үнэлгээг нийт 21 хоногт хийж, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх эхний гэрээг 4 сарын 1-ний өдөр байгуулсан бол сүүлийн гэрээг 5 сарын 10-ны өдөр байгуулжээ. */Хавсралт 5/*

2017 онд гэрээ байгуулах хүртэл нийт 70.0 сая, 2018 онд 96.4 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4²⁵, 8.5²⁶, 8.1.2²⁷, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-д заасныг тус тус зөрчиж байна.

Сумдын ЭМТ-д эм зүйч мэргэжилтэй, эм барих эрхтэй хүн байдаггүй тул ЭЭС-аар дамжуулан эмийн худалдан авалт хийж байна.

ЭЭС нь ЭМТ-д тендерийн баримт бичигт тусгагдсан эмийн үнэ, нэр төрөл, тоо хэмжээнээс зөрүүтэй нийлүүлэлт хийж байна.

Мөн ЭЭС-ийн эм, ЭМТ-ийн төсвөөр худалдан авах эм холилдсон, орлого, зарлага, үлдэгдэлд тооцоо нийлж баталгаажуулаагүй, батлагдсан төсвийн хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгслийг бүрэн авсан эсэх нь тодорхойгүй, эмийн үнэ, худалдан авалт, зарцуулалтад хяналт тавих боломжгүй байна.

Эрдэнэдалай, Говь-Угтаал сумын Сум дундын эмнэлгийн нягтлан бодогч нь ЭЭС-ийн нягтлан бодогчийн албан тушаалыг хавсран гүйцэтгэж байгаа нь ЭЭС-аас ЭМТ-д эм нийлүүлэх, төлбөр тооцоо хийх, хяналт тавьж, хараат бусаар ажиллах боломжгүй болгож байна.

Амжилттай болсон тендерийн хувьд эм, эмнэлгийн хэрэгслийн төлбөрийн шилжүүлгийг сумын ЭМТ-үүд харилцан адилгүй хийж байна.



²⁵ Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

²⁶ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

²⁷ Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

Дэлгэрцогт, Дэрэн, Баянжаргалан, Сайхан-Овоо сумын ЭМТ, Эрдэнэдалай, Говь-Угтаал сумын Сум дундын эмнэлэг эм, эмнэлгийн хэрэгслийн төлбөрийн шилжүүлгийг ЭЭС-аар дамжуулан ЭМГ-т хийдэг бол Хулд, Луус, Дэлгэрхангай, Адаацаг, Гурвансайхан, Өндөршил, Цагаандэлгэр, Өлзийт сумын ЭМТ-үүд мөнгөн шилжүүлгийг ЭМГ-т хийж байна.

Цаашид сумдад эм зүйч мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж, эмийн худалдан авах ажиллагаа, төлбөрийн шилжүүлгийг аймгийн хэмжээнд нэгдсэн бодлого, зохион байгуулалтын хүрээнд хийж байх шаардлагатай байна.



Нэгдсэн эмнэлгийн төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг нэр төрлөөр нарийвчлан тодорхойлох боломжгүй байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 12 төрлийн төлбөртэй тусламж, үйлчилгээ үзүүлж 2017 онд 78.5 сая төгрөгийн, 2018 оны 10 сарын байдлаар 105.3 сая төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Тусламж, үйлчилгээний орлогыг харилцах данс болон төвлөрсөн кассаар хүлээн авч төсөвт төвлөрүүлсэн боловч бэлэн мөнгөний гүйлгээ бүрийг кассын дэвтэрт хөтлөөгүй, кассын тайланд орлогыг нэр төрлөөр бус нийт дүнгээр тусгаж байна.

Тусламж үйлчилгээний орлогыг кассын дэвтэрт хөтөлж, нэр төрөл тус бүрээр тайлагнах, орлогыг бүрэн гүйцэд бүртгэж байх зөвлөмж өгч ажилласан.



Нэг их эмчид ногдох хүн амын тоо 2017 онд төвийн бүсийн аймгуудын дунджаас бага байгаа боловч нэг сувилагчид ногдох хүн амын тоо дунджаас өндөр байна.

График 4

Дундговь аймгийн хэмжээнд нэг их эмчид ногдох хүн амын тоо төвийн бүсийн аймгуудын дунджаас 2016 онд 27-оор, 2017 онд 43-аар бага байна.

2017 онд нэг их эмчид ногдох хүн амын тоо 326 болж өмнөх он оос 22-оор буурсан.

Нэг сувилагчид ногдох хүн амын тоо 2016 онд аймгуудын дунджаас 16-аар бага байсан бол 2017 онд 3-аар их болсон байна.


Нэг их эмч, сувилагчид ногдох хүний тоо, төвийн бүсийн аймгуудын дундажтай харьцуулсан үзүүлэлт



Мөн 2017 онд нэг сувилагчид 308 хүн ногдож, өмнөх оноос 15-аар өссөн байна.

Эмч, сувилагчийн ачааллыг сумдаар харьцуулан харуулбал:

Нэг их эмчид ногдох хүн амын тоо



2017 онд Өлзийт суманд нэг их эмчид 1,176 хүн ногдож байхад Сайнцагаан суманд 225 хүн ногдож байна.

Сайнцагаан сумын нэг их эмчид ногдох хүн амын тоо бага байгаа боловч сумдаас аймгийн эмнэлэгт ирж үзүүлж байгаа хүний тоо их байна. /График 5/

График 5

Сумдын нэг их эмчид ногдсон амбулаторын үзлэг, сумдаас Нэгдсэн эмнэлэгт ирж үзүүлсэн үзлэгийн харьцаа



Дэлгэрцогт, Дэрэн, Говь-Угтаал, Гурвансайхан, Хулд, Луус сумын нэг их эмчид ногдох амбулаторын үзлэг харьцангуй бага байгаа боловч аймгийн Нэгдсэн эмнэлэгт үзүүлж байгаа хүний тоо өндөр байна.

Сайнцагаан сумын ЭМТ нь лаборанттай²⁸ боловч тоног төхөөрөмж хүрэлцээгүйгээс шинжилгээ авахгүй байна. Шинжилгээ авдаг болсноор Нэгдсэн эмнэлгийн ачаалал, хүлээгдлийн хугацааг бууруулахад нөлөөлөх боломжтой.

Сайнцагаан сумын ЭМТ шинжилгээ хийхэд шаардлагатай тоног төхөөрөмжийг ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар иргэдээс авах саналын жагсаалтад оруулах ажлыг зохион байгуулж, олон нийтэд ач холбогдлын талаар сурталчлан ажиллах нь зүйтэй байна.


²⁸ эмнэлгийн лабораторийн ажилтан

График 6

2017 онд
Боржигон
мандал өрхийн
Эрүүл мэндийн
төвийн 1 их эмч
5,666
амбулаторын
үзлэг хийсэн бол
Дэлгэрцогт
сумын ЭМТ 760
буюу 7.5 дахин
бага үзлэг
хийсэн байна.



График 7




Нэг сувилагчид
ногдох хэвтэн
эмчлүүлэгчийн тоо
Нэгдсэн эмнэлэгт 94
байсан бол Өлзийт
сумын ЭМТ-д 21
буюу 4,5 дахин бага
байна.

Эмч, сувилагчийн
ачаалал эрүүл
мэндийн
байгууллагуудад
харилцан адилгүй
байгааг дээрх
үзүүлэлтүүд
харуулж байна.

Эмнэлгүүдийн орны фонд ашиглалтыг сумдаар авч үзвэл:

График 8

Орны фонд ашиглалтын дундаж хувь 54.1, 9 сумын ЭМТ-ийн орны фонд ашиглалтын хувь дунджаас доогуур үзүүлэлттэй байна.




Орны фонд ашиглалтын хувь 2017 онд аймгийн

Нэгдсэн эмнэлэг хамгийн өндөр буюу 90.6 хувь бол, Дэлгэрхангай сумын ЭМТ хамгийн бага буюу 30.6 хувьтай байна.

Нэгдсэн эмнэлэгт 2017 онд 6,008 хүн хэвтэн эмчлүүлснээс 389 хүн буюу 6.5 хувь нь бусад аймаг, хотоос ирсэн, 2,093 хүн буюу 34.8 хувь нь сумдаас ирж хэвтэн эмчлүүлэгчид байна.

График 9



Гурвансайхан, Өлзийт, Хулд, Луус, Дэлгэрхангай, Адаацаг сумын орны фонд ашиглалтын хувь бага байгаа боловч тус сумдаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт ирж хэвтсэн хүмүүсийн тоо их байна.

Эдгээр сумдын ЭМТ-ийн орны фонд ашиглалтыг сайжруулснаар Нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх ачаалал, хүлээгдлийг бууруулах боломжтой байна.

Стационарт²⁹ эмчлүүлсэн нэг хүнд ногдох эмийн батлагдсан төсөв 2017 онд Өлзийт суманд хамгийн өндөр буюу 123.1 мянган төгрөг бол, Адаацаг суманд 57.2 мянган төгрөг буюу 2.2 дахин бага төсөвтэй байна.

График 10



2018 оны эхний 11 сарын байдлаар Нэгдсэн эмнэлгийн эмч нарын үзлэгийн тоог тасгаар нь авч үзэхэд нүд, чих хамар хоолой, рентген оношилгооны тасгийн нэг эмчид ногдох үзлэгийн тоо хамгийн өндөр байгаа боловч тасаг доторх эмч нарын ачаалал харилцан адилгүй байна.

Тухайлбал дотрын тасгийн эмч нараас үзлэгийн тоогоор хамгийн их нь 5417 байхад хамгийн бага нь 604 буюу 9 дахин бага үзлэг хийсэн байна.

Эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт үйл ажиллагааны уялдаа, холбоог сайжруулан, байгууллага, эмч, ажилчдын ажлын ачааллыг жигд хуваарилах ажлыг зохион байгуулж чанартай, хүртээмжтэй, чирэгдэлгүй, тусламж, үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна.

2.2 Техник, технологийн хүрэлцээгүй байдлаас зарим эмчилгээ, оношилгоог хийх боломжгүй байна.



Судалгаанд хамрагдсан хүмүүсийн дийлэнх хувь нь эмч нарын ур чадвар, зан харилцаа, эмчилгээний үр дүнг “Дунд” гэж үнэлж байна.

№	Эмч нарын зан харилцаа, ёс зүйн тал дээр үнэлгээ өгнө үү		
	Хариулт	Хариултын тоо	Нийт хариултад эзлэх хувь
1	Сайн	420	35.8
2	Дунд	634	54.0

²⁹ Хэвтүүлэн эмчлэх

Хүснэгт 6

3	Муу	120	10.2
	Нийт	1174	100.0

“Эмч нарын зан харилцаа, ёс зүйн тал дээр үнэлгээ өгнө үү” гэсэн асуултанд 1,174 хариулснаас 634 хүн буюу 54.0 хувь нь дунд, 420 хүн буюу 35.8 хувь нь сайн, 120 хүн буюу 10.2 хувь нь муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

График 11



Сумдын болон өрхийн ЭМТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үр дүн муутай байна.


График 12

